

**ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.БААСАНСҮРЭНГИЙН  
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

2025.05.04

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /биелэлт /			
1	2	3	4	5		6	7	
<b>НЭГ. "ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮД, ЖЕНДЭРИЙН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ТАЙЛАГНАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>								
1.	Гэртээ хүүхдээ хардаг болон хувиараа бизнэс эрхэлдэг ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.	Хамрагдсан ээжүүдийн тоо	10	8	Гэртээ хүүхдээ хардаг болон хувиараа бизнес эрхэлдэг ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Эрдэнэтийн ээжүүдийн чадавхжуулах холбоо ТББ-тай хамтран оёдол, нэхмэл, эсгий урлал, гар урлалын чиглэлээр ээжүүдэд чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 30 гаруй эмэгтэйчүүд хамрагдаж, 5 ээж нэхмэл, гар урлалд чадавхжиж өөрийн санхүүгийн орлогоо нэмэгдүүлсэн үр дүнтэй байна. Тус холбоонд нийт 70 гаруй ээжүүд хамтран өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр оёдол, нэхмэл, эсгий урлал, гар урлалын 10 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний өрхийн үйлдвэрлэл явуулдаг. Мөн урлаг спортын тэмцээн уралдааны билэг тэмдэг Галхүү зөөлөн чихмэлийг 120ш, Эрдэнэт хотын билэг тэмдэг нэхмэл арслан 20 ширхэгийг ээжүүд хамтран урлаж 4.9 сая төгрөгийн орлого нэмэгдүүлсэн үр дүнтэй байна.		2025.01.01 2025.05.30	100
2.	Эмэгтэйчүүдийн хөгжил, манлайллын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	Хамтран ажилласан ТББ,	2	2	Эмэгтэйчүүдийн хөгжил манлайллын чиглэлээр 3 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж 47 сая төгрөгийн санхүүжилт олгосон. <ul style="list-style-type: none"> <li>➢ Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр "Эрдэнэсийн ээжүүд" нөлөөллийн арга хэмжээг "Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо, дуу хоолой" сэдвийн хүрээнд зөвлөгөөн зохион байгуулж, салбар бүрийн эмэгтэйчүүдийн төлөөлөл 400 эмэгтэй хамрагдсан.</li> <li>➢ Хувь хүний боловсрол судалгааны төв ТББ-тай хамтран Эмэгтэйчүүдийн хөгжил манлайллыг нэмэгдүүлэх, бизнесийн харилцааны ур чадвар олгох сургалтыг үйлчилгээний салбарын 50 эмэгтэйд зохион байгуулсан.</li> </ul>		2025.01.01 2025.05.30	100

					<ul style="list-style-type: none"> <li>➤ Эрдэнэтийн ээжүүдийн чадавжуулах холбоо ТББ-тай хамтран оёдол, нэхмэл, эсгий урлал, гар урлалын чиглэлээр ээжүүдэд чадавжуулах сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 30 гаруй эмэгтэйчүүд хамрагдаж, 5 ээж нэхмэл, гар урлалд чадавхиж өөрийн санхүүгийн орлогоо нэмэгдүүлсэн үр дүнтэй байна.</li> </ul>		
3.	Гэр бүлийн хөгжлийн цогц төвийг байгуулж, гэр бүлийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөлийн ажлыг зохион байгуулж гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх.	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	14515	7000	<p>Гэр бүлийн ордныг гэр бүлийн цогц төв болгон өөрчлөх зураг төсвийг 2025 оны орон нутгийн төсөвт тусгуулж, ажлын даалгаврыг батлуулж, зураг төсвийг “Үүлэн прожект” ххк- р гүйцэтгүүлэхээр гэрээг байгуулсан.</p> <p><b>Гэр бүлийн гишүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлийн боловсрол олгох сургалт, өдөрлөг, уулзалт зэрэг 52 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 6838 иргэн ба 1360 гаруй өрх хамрагдсан байна.</b></p> <p>Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ “Бүх хайраа гэр бүлдээ” сарын аяны хүрээнд гэр бүлийн өдөрлөг, гэр бүлийн 8 дадал сэдэвт Өглөөний уулзалт, залуу гэр бүлийн сэтгэл зүйн өдөрлөг, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйн сургалт, цахим нөлөөлийн арга хэмжээ зэрэг 8 төрлийн арга хэмжээнд 4114 гаруй иргэн хамрагдсан байна.</li> <li>➤ Гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Супер аав”, “Зоригтой хайр”, “Ээж охидын болзоо” уулзалтууд, Жендэрт суурилсан хүчирхийллээс өөрийгөө хамгаалах нь сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж давхардсан тоогоор 2724 иргэн хамруулсан байна.</li> </ul> <p><b>Үр дүн:</b> Гэр бүлийн гишүүд бүр үүрэг хариуцлагатай байснаар гэр бүлийн үнэ цэнэ бий болдог талаарх мэдлэг мэдээлэлтэй болсон.</p>	2025.01.01 2025.05.30	90
<b>ХОЁР. “ИРГЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЧИГЛЭСЭН ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУД, ЖЕНДЭРИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, ЛАВЛАГАА ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
1.	Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн		32000	15000	Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, “Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан” ажиллуулах гэсэн заалтын хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 22 багт 22	2025.01.01 2025.05.30	100

	<p>оролцоог нэмэгдүүлж, "Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан" ажиллуулах.</p>	<p>Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо</p>		<p>Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллаж байна. Эхний хагас жилд хүүхдийг эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус 19 байгууллагатай хамтран 35 удаагийн сургалт, олон талт арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 28,950 иргэнийг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Цахим орчин дахь хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх сургалтыг соёл, урлагийн байгууллага болон ЕБ-ын 7 сургуулийн нийт 403 хүүхэд залуучууд, албан хаагчдыг хамруулсан.</li> <li>➤ Мөн хорт зуршил, үе тэнгийн дээрэлхэлтийн сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр "Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй", "Үе тэнгийн дээрэлхэлт ба түүний хор уршиг", "Харах өнцөгтэй хайр нэмье" сэдвүүдээр 8 сургуулийн 4970 өсвөр үе, багш сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалагчийг хамруулсан. Мөн 6 төрлийн 1,535 ширхэг гарын авлага тархаасан.</li> <li>➤ Аврагч мазаалай болон Гүүмби Жүүмби 2 зэрэг видео контент, сургалтыг 36 сургуулийн 9321 хүүхдэд хүргэсэн.</li> <li>➤ "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийн хүрээнд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах мэдлэг олгох сургалтыг 19 сургуулийн 1521 хүүхдэд явуулсан.</li> <li>➤ "Өсвөрийн сэргийлэгч" явган аялал, дадлага сургуулилтад 200 гаруй сурагч оролцсон бөгөөд ахуйн ослоос урьдчилан сэргийлэх теле хичээлийг орон нутгийн 3 телевиз болон цахим сувгаар олон нийтэд 11,000 гаруй хандалттай байна.</li> </ul> <p><b>Үр дүн:</b> Сум, баг бүрд Хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтантай болсоноор хамтын ажиллагаа нэмэгдэж,</p>		
--	---	--	--	--	--	--

					хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлын хүртээмж нэмэгдсэн.			
2.	Хүүхдийн хамгааллын үйл эрчимжүүлэн, дундын үйл сайжруулж, шалгалтыг байгуулах.	эрх, чиглэлээрх ажиллагааг салбар ажиллагааг хяналт зохион	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлтийн тоо	606	320	<p><b>Тайлант хугацаанд 335 хүүхдийг шинээр илрүүлэн бүртгэж, нийт бүртгэлтэй 941 хүүхдийг хяналтад авч ажиллаж байна. Үүнээс 42 өрхийн 145 хүүхдэд кейс нээн хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан.</b> Эрсдэлийн програмд бүртгэлтэй хүүхдүүдэд шаардлагатай хамгааллын үйлчилгээг үзүүлж, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ “Сэтгэл зүйн цогц боловсрол” НҮТББ-тай хамтран “Гэр бүлд суурилсан сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 16 багийн эрсдэлийн программд бүртгэлтэй 38 хүүхэд, 30 эцэг эхийг хамруулан нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэв. Мөн өндөр эрсдэлтэй 107 өрхийн 297 хүүхдэд эргэн хяналт хийж, эрсдэлийн үнэлгээг дахин шинэчилж 42 өрхийн 107 хүүхдэд кейс нээн ажиллаж байна.</li> <li>➤ 2020 оноос хойш үрчлэгдсэн 170 хүүхдийн судалгаанд тодотгол хийж үзэхэд 51% нь хойд эцэг, 12% эмээ, өвөө, 17% нагац, авга, үлдсэн 20% нь садан төрлийн бус хүмүүст үрчлэгдсэн байна.</li> <li>➤ 41 өрхийн 55 хүүхдийн хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой өргөдөл хүсэлтийг шийдвэрлэж, 55 хүүхдийн тэтгэмжийг түр зогсоож, хариу арга хэмжээ авч, холбогдох байгууллагад хүргэж, ажилсанаар 30 хүүхдийн тэтгэмжийг сэргээн шийдвэрлэж, 25 хүүхдийн тэтгэмжийн асуудалд ажиллаж байна.</li> </ul> <p><b>Үр дүн:</b> Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа сайжирч, салбар дундын хамтын ажиллагаа эрчимжсэнээр эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг эрт илрүүлж, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх боломж нэмэгдсэн.</p>	2025.01.01 2025.05.30	100
3	Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээг		Хүүхэд харах болон	15	15	Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2 иргэнд шинээр хүүхэд	2025.01.01 2025.05.30	100

	нэмэгдүүлэн, эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх.	өдөр өнжүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо			харах үйлчилгээний зөвшөөрлийг олгосон. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар хүүхэд харах үйлчилгээнд 21 хүүхэд, өдөр өнжүүлэх төвд 148 хүүхэд хамрагдаж байна. Хагас жилийн байдлаар хүүхэд харах үйлчилгээнд улсын төсвөөс нийт 34.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хүүхэд харах үйлчилгээ үзүүлж байгаа 5 иргэнд "Бага насны хүүхдийн хөгжлийн онцлог", хүүхэд хамгааллын тухай хууль танилцуулах сургалтад хамруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. Мөн хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээг үзүүлдэг иргэн хөгжлийн төвүүдийн албан хаагчдад сэтгэл зүйн "Сэтгэл нэмье" сургалт, нөлөөллийн ажлыг 5 удаа зохион байгуулж, 40 хүн хамрагдсан. <b>Үр дүн:</b> Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулсанаар эцэг эхчүүдийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгож байна.		
4	Хүүхдийн зуслангийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагаа явуулж буй зуслангуудад мэргэжил, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх.	Зусланд хамрагдсан хүүхдийн тоо	4200	1000	Хүүхдийн Янзага зуслангийн үйл ажиллагааг дэмжиж 525.0сая төгрөгийг засварын ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>➢ Хүүхдийн "Янзага" зуслангийн цахилгаан хангамж КТП-н засвар үйлчилгээний ажлыг "Сервис по сименс" ХХК 75,0 сая төг-ийн санхүүжилттэй гүйцэтгэж ажлын хэсэг хүлээлцсэн.</li> <li>➢ Янзага зуслангийн их засварт 450.0 сая, засварын ажлыг "Мээжийн хишиг" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд гүйцэтгэл 90 хувьтай байна. Тайлант хугацаанд хоолны заал, склад, талхны цех, захиргаа, эмнэлэгийн байр, хүүхдийн амралтын 2 байр /мансардтай/, улаан булангийн засвар үйлчилгээ хийгдэж дуусаад байна.</li> </ul> <p>Янзага зуслангийн үйл ажиллагааг 6-р сарын 25-наас эхлүүлэхээр "Зуслан хөтөлбөр"-ийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p>	2025.01.01 2025.05.30	100
5	Залуучуудад чиглэсэн амьдрах ухаан, хувь хүний хөгжил, гэр бүл,	Нийт залуучуудын хувь	30%	15%	Залуучуудад чиглэсэн хувь хүний хөгжил, гэр бүл, эрүүл мэндийн боловсрол олгох нийт 27 удаагийн уулзалт, сургалт, хэлэлцүүлэг, чуулган, нийгмийн нөлөөллийн арга	2025.01.01 2025.05.30	90

	<p>эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлэх.</p>				<p>хэмжээ, арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 5200 орчим залуу буюу нийт залуучуудын 18.6 хувийг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Залуучуудын хөгжил оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Залуучуудын оролцоо – Өөрчлөлт” уриатай залуучуудын нэгдсэн чуулганыг зохион байгуулж, 400 гаруй залуучууд хамрагдаж, тэднээс гарсан санал санаачлагыг нэгтгэн холбогдох байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн.</li> <li>➢ “ACTIVE TIME” “Хүлээсгүй, эрх чөлөөтэй залуус” нэртэй чэлленжит арга хэмжээг соёл, урлагийн байгууллагын залуу ажилтнуудад зориулан амжилттай зохион байгуулж, 30 гаруй залуус хамрагдаж, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, багийн уур амьсгалыг сайжруулах арга зүйд суралцсан.</li> <li>➢ Залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор “Би найзынхаа итгэлтэй зөвлөх” арга хэмжээг өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн болон сэтгэлзүйн боловсрол олгох сургалтыг үе шаттай зохион байгуулж, ЕБС-ийн 12 сургуулийн 1368 сурагчийг хамруулсан. Мөн эрүүл амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 8 төрлийн цахим зөвлөмж, постер бэлтгэн олон нийтэд хүргэж 3500 гаруй хандалт авч, нийгмийн сэтгэл зүйд эерэг нөлөө үзүүлсэн.</li> <li>➢ Баян-өндөр сум багийн залуучуудын салбар зөвлөлтэй хамтран “Хосын харилцаа – Сэтгэл эдгэрнэ”, “Хоггүй Эрдэнэт хот”, “Манлайлал”, “Залуусын оролцоо – Нийгмийг өөрчилнө”, “Өв уламжлалаа дээдлэн – Залуус бид хамтаръя” зэрэг олон талт сургалт, нөлөөллийн арга хэмжээ, аян зохион байгуулж, нийт залуучуудын 18.6 хувийг хамруулсан.</li> </ul>		
6	<p>Залуучуудын сайн дурын ажилд оролцох идэвх, санаачлагыг дэмжин олон улсын туршлага судлах хөтөлбөрт холбон зуучилах, сайн дурын</p>	<p>Сайн дурын ажилд оролцсон иргэдийн тоо</p>	2025	1100	<p>Залуучуудын сайн дурын ажилд оролцох идэвх, санаачилгыг дэмжин олон улсын туршлага судлах хөтөлбөрт холбон зуучлах ажлын хүрээнд Улаан загалмайн байгууллага болон Хүүхдийн оролцооны байгууллага, Сурагчдын өөрөө удирдах зөвлөлтэй хамтран сургалт нөлөөллийн олон талт арга хэмжээг зохион байгуулж</p>	<p>2025.01.01 2025.05.30</p>	100

	ажилтанд батламж, урамшуулал олгох.				<p>давхардсан тоогоор 1160 гаруй өсвөр үе хүүхэд залуучуудыг хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Өсвөрийн болон залуучуудын улаан загалмайн 2025 оны идэвхжүүлэх хөдөлгөөнд 1000 орчим хүүхдийг гишүүнээр бүртгэж, үнэмлэх олгож, чадавжуулах сургалтыг “Дээрэлхэгч биш дэмжин ажиллагч байя” уриан дор нөлөөллийн ажлыг 2 удаа зохион байгуулсан.</li> <li>➢ Хүүхдийн оролцооны байгууллагын идэвхтэн гишүүдийн дунд “Good neibor’s” олон улсын байгууллага болон ТББ-тай хамтран “Байгальд ээлтэй залуус чуулган”, илтгэлийн уралдааныг зохион байгуулж, 160 гаруй өсвөр үе залуучуудыг хамруулсан.</li> </ul> <p>Залуучуудын нийгмийн идэвх оролцоо нэмэгдэж, сайн дурын ажилд оролцох, үүрэг хариуцлагын талаар мэдлэг ойлголттой болсон.</p>		
7	Иргэд, олон нийтийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг үзүүлэх.	Сэтгэл зүйн сургалт, зөвлөгөөнд хамрагдсан иргэдийн тоо	2500	1500	<p>Иргэдийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалт нөлөөллийн ажлын хүрээнд нийт 153 иргэнд (хүүхэд – 75, насанд хүрэгч – 78) ганцаарчилсан зөвлөгөө өгч, 20 удаагийн сургалт, бүлгийн зөвлөгөөг зохион байгуулан 1,149 иргэнийг хамрууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр ШШГГ, ЦГ- тай хамтран 5 удаагийн сэтгэлзүйн сургалтад 100 иргэнийг хамруулсан. мөн гэр бүл салалт, хүүхдийн асрамж тогтоохтой холбоотой 7 өрхийн 25 хүүхдэд сэтгэлзүйн оношлогоог хийж, зөвлөгөө өгсөн. Мөн Сэтгэл зүйн явуулын үйлчилгээний хүрээнд Жаргалант сум, Политехник коллежийн нийт 65 сурагч, оюутанд бүлгийн ярилцлага, 3 хүүхдэд ганцаарчилсан зөвлөгөө үзүүллээ.</li> <li>➢ Эрсдэлийн програмд бүртгэлтэй хүүхдүүдэд зориулсан “Би болон бидний ирээдүй” сэтгэл зүйн боловсрол олгох сургалтыг 8 удаагийн давтамжтайгаар Наран, Уртын гол, Рашаант, Цагаанчулуут багийн 150 иргэнд зохион байгуулж,</li> </ul>	2025.01.01 2025.05.30	90

					<p>ганцаарчилсан зөвлөгөөг үзүүлсэн ба “Тэмүүлэлтэй өсвөр нас”, “Өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн аялал” бүлгийн сургалт, зөвлөгөөнд 874 иргэнийг хамруулсан байна.</p> <p><b>Үр дүн:</b> Иргэд олон нийтийн сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол дээшилж, өөрийгөө хянах, сэтгэл гутралаа даван туулах, аргад суралцсан.</p>		
8	<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, жендэрийн талаарх ойлголтыг иргэд олон нийтэд олгох сургалт нөлөөллийн болон Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах.</p>	Хамрагдсан иргэдийн тоо	5500	3000	<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар 2024 оны хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж, аймгийн ИТХ-ын зөвлөлийн хурлаар тайланг хэлэлцүүлж, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн. 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналыг байгууллагуудаас авч, нэгтгэн төлөвлөгөөг Засаг даргын захирамжаар батлуулсан. Мөн жендэрийн үндэсний хороо, Азийн хөгжлийн банк хамтран зохион байгуулж буй “Азийн эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-т орон нутгаас 1 эмэгтэй удирдагчийг хамруулсан.</p> <p>Иргэд олон нийтэд жендэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр “Жендэрийн ерөнхий ойлголт”, “Жендэрт суурилсан хүчирхийлэл”-ийн тухай сургалтыг 5 байгууллагын 152 албан хаагч хамрагдаж, тэдний жендэрийн тухай мэдлэг ойлголт нэмэгдсэн.</p> <p>Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан ажлын байран дахь жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт сургалтад 12 удирдах ажилтанг онлайнаар хамруулж тэдний ажлын байран дахь жендэрийн тухай мэдлэг ойлголт сайжирсан. Өсвөр үе хүүхэд багачуудад хөгжил хамгааллын өдрийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 2 ТББ-тай гэрээ хийж, 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.</p>	2025.01.01 2025.05.30	80
<p>ГУРАВ. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ, ЗӨВЛӨМЖ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</p>							

1.	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Холбогдох албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна	-	Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох газарт хүргүүлсэн байна.	<ul style="list-style-type: none"> <li>➤ ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, хэлтсийн даргаар батлуулсан.</li> <li>➤ Төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд нийт 17 бичиг ирсэн. Холбогдох нэгж, агентлагтай хамтран ажиллаж хугацаанд нь шуурхай гүйцэтгэсэн.</li> </ul>	2025.01.01 2025.05.30	100
2.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хууль тогтоожийн хэрэгжилт		Хууль тогтоомжын хэрэгжилтийг ханган ажиллана	<ul style="list-style-type: none"> <li>➤ Тайлант жилийн хугацаанд хагас жилийн байдлаар нийт 6 өргөдөл ирсэн. Холбогдох байгууллагад нь мэдээлэл хүргэн хамтран ажиллаж хугацаанд нь шуурхай гүйцэтгэсэн.</li> </ul> <p>Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн, авлига ашиг сонирхлоос ангид ажилласан.</p>	2025.01.01 2025.05.30	100
	Өргөдөл гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо 20	Өргөдөл гомдлын тоо 15	Өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байх	<ul style="list-style-type: none"> <li>➤ Тайлант жилийн байдлаар нийт 7 өргөдөл, хүсэлт ирсэн. Холбогдох нэгж газартай хамтран мэдээлэл хүргэн, хамтран ажиллаж хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн.</li> </ul>	2025.01.01 2025.05.30	100
	Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр	Комисс, ажлын хэсэгт	тоо 5	Шийдвэрийн дагуу	Засаг даргын захирамжаар байгуулагдсан 3 ажлын хэсэгт орж ажилласан. Үүнд	2025.01.01 2025.05.30	100

	байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх	ажилласан тоо 7		ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>➤ 2025 оны 03 дүгээр сарын 07 ний өдрийн А/189 тоот захирамжаар байгуулагдсан өсвөр үе залуучуудын Япон улсын тоокамачи хоттой “сурагч солилцоо” арга хэмжээнд оролцох сурагчдыг шалгаруулах ажлын хэсэг,</li> <li>➤ 2025 оны 05 дугаар сарын 01 ний өдрийн А/363 тоот захирамжаар байгуулагдсан Гэр бүлийн өдрийг зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар,</li> <li>➤ 2025 оны 05 дугаар сарын 07 ний өдрийн А/388 тоот захирамжаар Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр Хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг</li> <li>➤ Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт тус тус шийдвэрийн дагуу ажилласан.</li> </ul> <p>Мөн байгууллагын шуурхай хуралдаанаас нийт -18 үүрэг даалгавар ирснийг холбогдох байгуулагуудад хүргэж, хэрэгжилтийг удирдлагуудад танилцуулж шуурхай гүйцэтгэж ажилласан.</p>		
--	---	-----------------	--	---------	--	--	--

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин					
		Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин биелэлт	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Байгууллагын зүгээс зохион байгуулсан сургалт үйл ажиллагаанд хамрагдах.	Өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдсан байна.	Ажил үүргийн холбогдолтой сургалт үйл ажиллагаанд	1	<p>Байгууллагын зүгээс зохион байгуулсан нийт 6 сургалтад хамрагдсан. Үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Байгууллагын соёл ба ёс зүйн сургалт</li> <li>➤ Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт ба төсөвлөлт</li> <li>➤ Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургалт</li> <li>➤ Хойд бүсийн чуулган зэрэг байгууллагаас зохион байгуулсан сургалт үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдсан.</li> </ul> <p>Мөн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдаж буй сургалтуудад тухай бүрд нь оролцож байна.</p>	2025.01.01 2025.05.30	100

2.	Япон улсын хүүхэд хүмүүслийн эерэг арга "ТОККАЦУ" сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан байна.	-	1	Япон боловсролын онцлог "Токкацү" төсөл Орхон аймагт 3 дахь жилдээ амжилттай хэрэгжиж байна. Орон нутгийн төсвөөс 2023 онд 40.0сая, 2024 онд 40.0сая, 2025 онд 20.0 сая төгрөг тус тус санхүүжүүлсэн. Төслийн хүрээн хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй модуль сургалтын орчуулага, зохион байгуулалтыг хариуцан ажиллаж, "Токкацү"-ыг түгээн дэлгэрүүлэх сургагч багшийн сертификат авсан. Токкацү төслийн хүрээнд бага ангийн 315 багш анхан шатны мэдлэг ойлголттой болсон. 27 багш Япон улсад туршлага судалж, сургагч багшаар бэлтгэгдсэн. Тайлант онд Японы боловсролын онцлог Токкацүг түгээн дэлгэрүүлэх ажлын хүрээнд нийт 6 сургалт, 10 хэлэлцүүлэг хичээл, эцэг эх асран хамгаалагчдын дунд хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 950 гаруй багш, удирдлага, асран хамгаалагч нар хамрагдаж, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүйд суралцсан.	2025.01.01 2025.05.30	100
----	---	-----------------------------	---	---	--	--------------------------	-----

**ТАЙЛАН ГАРГАСАН :**

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД,  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН  
( Албан тушаал )

Н.БААСАНСҮРЭН / *H. Baasan*

2025.05.15

( Нэр, гарын үсэг )

( Огноо )

